

基調講演Ⅲ



「モンゴルの国語教育カリキュラム開発—
生徒の読解力育成の現状と今後の課題」

Sh. OYUNTSETSEG

教育文化科学スポーツ省 教育研究所
言語社会人文局 局長

略歴：

所属先： 教育文化科学スポーツ省、教育研究所、言語社会人文局 局長

学位： 教育学修士

研究分野： 国語・文学教育、初中等教育の質的向上の対策、初中等教育カリキュラム開発、カリキュラムの実践方法、教科書開発法等

講演するにあたって： どうして今回のシンポジウムで発表することになったか。

まず、モンゴル日本語教師会からモンゴル人日本語学習者の読解力に関することで発表するよう、お願いが来た。また、初中等教育機関で働いている日本語の教師らが教師免許などのことで相談に来ることが多く、モンゴル日本語教師会とのこれからの協力が大切だと思った。現在、モンゴルに 3000 人の外国語の教師（初中等教育機関）がおり、これら教師の教授法や専門的な知識向上のための研修、セミナーを教育研究所が担当している。その意味で、モンゴル・日本人材開発センターや教師会が担当する勉強会、研究会への参加も日本語教師への評価として認めることも考えている。私は、母語教育、教科書開発に関する研究をってきている。

Илтгэлийн агуулга

Монгол хэл бичгийн сургалтын агуулга-
сурагчдын унших чадвар

- ▶ 1. Орчин цагийн боловсролын үүсэл, хөгжил
- ▶ 2. Монгол хэл бичгийн сургалтын агуулгын хөгжил
- ▶ 3. Унших чадвар

Ш. Оюунтsetseg (БМДИ-ийн Хэл, нийгэм, хүмүүнлэгийн
ухааны сургалтын албаны дарга)

Орчин цагийн боловсролын үүсэл, хөгжил

- ▶ 1921-1940 Сургууль, гэгээрлийн байгууллага байгуулагдаж бэхэжсэн үе
- ▶ 1941-1958 Бүх нийтийг бага боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн үе
- ▶ 1958-1986 Бүх нийтийг бүрэн бус дунд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн үе
- ▶ 1990- оноос Боловсролын тогтолцоог шинэчлэх, олон улсын жишигт нийцүүлэх зорилтыг хэрэгжүүлж байгаа үе

Хоёр. Монгол хэл бичгийн сургалтын агуулгын хөгжил



3

4

Бага ангийн монгол хэл, унших- үг хөгжлийн хичээл

Сургуулийн бүтэц	Анги	I	II	III	IV	V	VI
	Хөтөлбөр						
4	1925, 1926	6/ 8	6/10	6/12	12		
4	1933	12	12	12	12		
4+4+2	1940	14	14	10	10		
4+4+2	1946	14	14	9	9		
4+4+2	1955	14	14	15	9		
4+4+2	1964	12	12	12	9		
3+5+2	1972	12	12	12			
3+5+2	1987	13	11	11			
4+4+2	1998	12	11	11	9		
5+4+2	2005	8	8	8	7	7	
5+4+3	2013	8	8	8	7	7	

Бага ангийн унших- үг хөгжлийн хичээл

- ▶ Сурагчдад уншлагын зөв, ойлгож, хурдан, уран яруу унших 4 чанарыг эзэмшүүлэх
- ▶ Сурагчдыг номыг зөв ашиглах дадал чадвартай, ном унших дур сонирхолтой болгох
- ▶ Унших-үг хөгжлийн хичээл нь хүрээлэн байгаа орчин, байгаль нийгмийн амьдралын олон талт үзэгдэл, хууль зүй тогтлын талаар мэдлэг эзэмшүүлэх
- ▶ Уншлагын дадал чадвар олгох явцад хэл яриаг хөгжүүлэх
- ▶ Унших-үг хөгжлийн хичээл нь хүүхдийн хүмүүжилд, ялангуяа ёс суртахуун, гоо зүй, хөтөлбөрийн хүмүүжилд чухал ач холбогдолтой.

5

6

Унших чадвар, уншлагын чанар



Уншлагын хурд

Анги	Бусдад унших	Өөртөө унших
I	30-аас доошгүй	40-аас доошгүй
II	50-аас доошгүй	70-аас доошгүй
III	75-аас доошгүй	85-аас доошгүй
IV	100-110	130-170
V	110-120	170-210
VI	120-130	210-250
VII	130-180	250-270
VIII	180 орчим	270-290
IX	180 орчим	190-310
X	180 орчим	

Бага анги: Нэг минутад унших хурдны стандарт (Оюун Ц, 1997)
Дунд, ахлах анги: Монгол хэл, уран зохиолын хөтөлбөр, 1985

7

8

Унших үйл



Дунд, ахлах ангийн уран зохиолын хичээлийн цаг

Сургуулийн бүтэц	Анги									
	Он	IV	V	VI	VII	VIII	IX	X	XI	XII
4+4+2	1940		2	2	2	2	3	2		
4+4+2	1946		2	2	2	4	3	3		
4+4+2	1955		2	2	2	4	4	4		
4+4+2	1964		2	2	2	3	4/5	3/2		
3+5+2	1972		2	2	2	2	4	3	4	
3+5+2	1987		2	2	2	2	4	3		
4+4+2	1998		2	2	2	2	3	3		
5+4+2	2005			2	2	2	2	1	1	
6+3+3	2009									
5+4+3	2013									

9

10

1960-1990: Уран зохиолын хичээлийн зорилго

IV-VIII ангид уран зохиолын уншлагын зорилго:

- Сурагчдын ном унших сонирхлыг өрнүүлэх, номд дуртай болгох, эх зохиолд үндэслэлтэй тайлбар хийж сургах
- Алдаагүй зөв, шударга, уран яруу, утга төгөлдөр, ойлгож унших чадварыг сурагчдад эзэмшүүлэх зорилготой.

IX-X ангийн уран зохиолын хөтөлбөрийн зорилго:

- Судалж байгаа зохиолд өгүүлэгдэж байгаа цаг үеийн тэргүүний үзэл санаа, нийгмийн амьдралд уран зохиолын гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн холбоог сурагчдад системтэй ойлгуулах

11

Дунд, ахлах ангийн уран зохиолын сургалтын агуулгын хөгжил

- Монгол аман зохиол (үлгэр, ерөөл, дуу ...)
- Монголын эртний сонгодог уран зохиол (МНТ, Алтан ордны үйсэн дээрх бичиг, Равжаа...)
- Монголын орчин үеийн уран зохиол (Д.Нацагдорж, Ч.Чимэд ...)
- Гадаадын уран зохиол (М.Горький, Л.Толстой ...)

- Үзэл суртлаас ангид, ур чадвар сайтай зохиолыг сонгох
- Шинэ нийгмийн иргэн төлөвшүүлэх ур сайхны чадавх сайтай зохиол сонгох
- Сэдэв хоорондын уялдаа холбоог анхаарах
- Уран зохиолын онолын ойлголт өгөх
- Сурагчдад бие дааж авьяас сонирхлоо хөгжүүлэх боломж олгох

12

1990-оноос хийсэн шинэчлэл

- Үзэл суртлын хүчтэй нөлөөн дор хийгдсэн хуучин агуулгаас татгалзаж, монгол заншил, бурхны шашин, ёс суртахууны сэдэвт зохиолыг нэмсэн. (Д.Пүрэвдорж "Чингис", Дашдооров "Өндөр эзж")
- Үндэсний уламжлалт бичгийн зохиол, ААЗ-ыг түлхүү оруулсан. ("Убаши хун тайжийн тууж", Бөө мөргөлийн яруу найраг)
- Дэлхий сонгодог зохиолоос хүнд, ховор зохиолыг агуулгаас хассан. (Л.Толстой "Дайн ба энх" роман ...)
- Монголын орчин үеийн зарим үзэл сурталжсан зохиолыг хассан. (Ц.Дамдинсүрэн "Хоёулаа миний хү", "Д.Сэнгээ "Өвгөн партизаны яриа")
- Нэрд гарч байгаа зарим зохиолчдын бүтээлээс оруулсан. (Б.Лхагвасүрэн "Боржигоны бор тал", "О.Дашбалбар "Залуус дүү нартаа хүргэх шүлэг")

13

Хөтөлбөрийн шинэчлэл

2009-2013

- Бага анги: Монгол хэл I-Y анги**
- Унших
 - Ярих- сонсох
 - Бичих
 - Хэл зүй, зөв бичих дүрэм
- Дунд анги: VI-IX анги**
- Монгол хэл
 - Уран зохиол
 - Монгол бичиг
- Ахлах анги: X-XI анги**
- Монгол хэл
 - Уран зохиол

Бага анги: Монгол хэл I-Y анги

- Унших
- Ярих- сонсох
- Бичих
- Хэл зүй, зөв бичих дүрэм

2014-2016

Дунд анги: VI-IX анги

- Монгол хэл
 - Уран зохиол
 - Монгол бичиг
- Нэгдмэл

Ахлах анги: X-XI анги

- Заавал судлах:
- Монгол хэл, бичиг, уран зохиол
 - Сонгон гүнзгийрүүлэх:
 - Монгол хэл, бичиг
 - Уран зохиол

14

Хөтөлбөрийн шинэчлэл

Дунд ангийн хөтөлбөр 2015 он

- ✓ Үгийн урлагийг мэдэрч, тусган хүлээж авах чадвар
- ✓ Задлан шинжлэх, тайлан тайлбарлах, харьцуулах, эсрэгцүүлэх, холбоолох, үндэслэх зэрэг мэдээлэл боловсруулах чадвар
- ✓ Шүүмжлэх ба бүтээх чадвар: аналитик бичвэр ба уран дүрслэлт бичвэр бүтээх
- ✓ Хувийн болон нийгмийн харилцааны чадвар

Ахлах ангийн хөтөлбөр 2016

- ✓ Яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн хэлбэрээр бичсэн сэтгэл зүйн зохиолыг мэдэрч хүлээн авах
- ✓ Зохиолд туссан түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд эргэцүүлэх, далд санааг ойлгох
- ✓ Өөр өөр цаг үеийн, өөр өөр соёлын ижил сэдэвтэй зохиолын бүтэц, утга сэдэв, дүр, орчин, өнгө аяс зэрэг бүрэлдэхүүн хэсгийг задлан шинжилж, харьцуулах
- ✓ Уран зохиолын төрөл зүйл, ангилал, бичлэгийн хэлбэр, хэл найруулгыг судлах
- ✓ Уншсан зохиолоос төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн харилцах
- ✓ Зохиолд дөвшүүлсэн асуудлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх, шүүмжлэлтэй хандаж, судалгааны бичвэр бүтээж эхлэх
- ✓ Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцан уран дүрслэлт бичвэр бүтээх

Монгол хэл бичиг		Ү1	ҮII	ҮIII	IX	Нийт
		Монгол хэл	105	70	70	70
Уран зохиол		70	70	70	70	280
Үндэсний бичиг		70	70	70	70	280
		245	210	210	210	875

Хичээл судлагдахуун 20.4%
Хичээлийн жилийн нийт цагийн 18.6%

15

16

Унших чадварын судалгааны үр дүнгээс

- ▶ 2004-2006 онд БСШУЯ-ны "Бага боловсролын сурлагын амжилтын үнэлгээ" үндэсний судалгаа - 48,6%
(Сурлагын амжилтыг үнэлэх үндэсний судалгаа, <http://www.eec.mn/page17710>)
- ▶ 2007-2008 онд БСШУЯ, БҮТ-ээс зохион байгуулсан "Бага боловсролын математик, унших чадварын үндэсний хэмжээний судалгаа" –гаар унших чадварын дундаж -48%, эхийн утгыг ойлгох, эхийн утга санааг олох даалгаврын гүйцэтгэл -18,0 хувь буюу маш хангалтгүй гүйцэтгэсэн.
(Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ, БҮТ, 2008, 38-р тал)
- ▶ 2012 онд БҮТ-өөс стандартын хэрэгжилтийн түвшин тогтоох шалгалтын дүн: 7-р ангийн сурагчдын 50,2%, 10-р ангийн сурагчдын 47,9% нь (F) түвшинд үнэлэгдсэн.
(72050, 1011677), (<http://www.eec.mn/page17710>)

17

2016 оны чанарын үнэлгээний шалгалтын сэдэв

- I. Уран зохиолын бус эхэд суурилсан даалгавар: "Асралт хайрхны оргилд" эхийг 15 минутад унших
Гүйцэтгэх даалгавар: **75 минут**
- A. Уулын аваргалдаг оролцсон нэг залуу бархшээлийг бэлтгэлээр давдгийг ямар үг хэллэг, бичлэгийн ямар арга барил ашиглан өгүүлсэн байна вэ? Эхийн үг хэллэг, бичлэгийн арга барилыг өөрийн үгээр дүгнэн бичээрэй.
Үеийн тоо 300-350 /25 оноо/
- B. "Асралт хайрхны оргилд" эхийн үг хэллэг, бичлэгийн ямар арга барил ашиглан үг тэгийгхэдээ зохиулан байгалийн саяоныг баядан шалгасан, түүнийг хэрхэн хайрлан хамгаалах тухай тэмдэглэл, зөвлөмж бичээрэй.
Үеийн тоо 300-350 /25 оноо/
- II. Уран зохиолын бус эхэд суурилсан даалгавар: "Зээ хүү" эхийг 5 минутад унших
Гүйцэтгэх даалгавар: **40 минут**
- A. Ж.Сарантуяагийн "Зээ хүү" эхэд "Хар Жаллаа зэгээ хэрхэн хайрлан, өмгөөлөн өсгөж байгаа тухай" тухай санааг дорхон өгүүлснэ ямар үг хэллэг, бичлэгийн арга барилыг ашиглан гэгдсэн хэргийн бөгөөд 4 ашлалт баримт ашиглан тайлбарлаарай.
Үеийн тоо 300-350 /25 оноо/
- B. Дараах сэдвээс зөвхөн НЭГИЙГ сонгон эх зохион найруулж бичнэ.
Үеийн тоо 300-350 /25 оноо/
- "Алаг дэлхийд төрсөн минь учиртай" санааг баримт мэдээгээр баяжуулан эх зохион найруулаарай.
Цөлийн диваажин болгоосон нь "санааг уран согтгожир" баяжуулан зөгвөн бичээрэй.
"Залуу хүний заавал унших ном" сэдвээр найа нөхдөө унштал уулуулж гуггасан эх зохион найруулж бичээрэй.

18

Дүгнэлт

- ▶ ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөрийг монгол хэл, уран зохиолын сургалтын өнөө хүрсэн уламжлал, туршлага, суртамжид үндэслэн, олон улсад эх хэлний боловсрол олгож байгаа жишигт нийцүүлэхийг зорьсон шинэчлэл хийж байна.
- ▶ Монгол хэл, уран зохиолын сургалтад ашиглах зохиол бүтээлийг сонгохдоо хүүхдийн хүмүүжил төлөвшилд зэрэг нөлөө үзүүлэхээр, монгол хэл соёл, уламжлалт ахуй хэл найруулгын хувьд үлгэр жишээ болохуйц байхыг чухалчилж байна.
- ▶ Бага, дунд, ахлах ангид сурагчдын эзэмшсэн унших чадварын түвшин тогтоох даалгавар боловсруулах, ялангуяа олон улсын жишигт нийцсэн арга зүйд суралцах шаардлагатай байна.

19



20

「モンゴルの国語教育カリキュラム開発—生徒の読解力育成の現状と今後の課題」

Sh.オユンツェツェグ 教育文化科学スポーツ省 教育研究所 言語社会人文局 局長

1. 教育部門の開発

モンゴル国において、1921年から近代的教育の土台が作り始められたとみられている。それ以後、当国では国民の教育・育成の展望のため以下の対策が取られた。

- 1) 1921年～1940年 学校・教育機関が設立され、読み書きができるようにする時代
- 2) 1941年～1958年 国民全体に初等教育を育成する時代
- 3) 1958年～1986年 全国にいる、通学年齢の子供たちに対する義務教育実行の時代
- 4) 1990年代以後 教育制度を改善し、国際基準に一致する教育制度に移行する対策の時代

モンゴルの教育・学校の制度も更新されてきた。例えば、1950年代ごろには7学年制度、1960年代から8学年制度、10学年制度の中等教育制度が作られた。2005年代からは中等教育が11学年制度、2013年から12学年制度となった。入学年齢は2004年から7歳、2008年から6歳にされ、若くなった。

2. モンゴル語学学習の内容とその展望

モンゴルの伝統的な学習施設と公立教育施設において学習する基本科目はモンゴル語学である。この科目の伝統的学習の概念はモンゴル語の表音文字を暗記させ、読み書きを育成することだった。従来、モンゴル語学に関する学習内容はこの方法を基にして、さらに展開してきた。1921～1941年までの中等教育機関での授業はモンゴルたて文字を使っていたが、1941年代から新文字であるキリル文字を使うようになった。

モンゴル語学学習の概念を以下のように区分化することができる。

1) 伝統学習方法が中心とされた時代 1921—1934(モンゴルたて文字)

この時の学習の主な内容は読む、書く、文を作ることであった。生徒たちにモンゴルたて文字を教え、できるだけたくさん読ませる、書かせる、はなさせるような練習をさせ、それぞれの力を伸ばす訓練が多かった。

2) 文法学習の開始 1934—1946 (モンゴルたて文字)

初等教育におけるモンゴル語学学習概念が拡大され、1934年から文法科目が新しく加入された。1941年から、初・中等学校において新文字つまりキリル文字を教え始めた。モンゴル語学学習のカリキュラムの中に音声、語彙、文章の構成といった科目が新しく加えられ、それらの概念が年々増大されていき、全学習科目の7割を示すようになった。1940年から総合教育学校の9、10学年になると海外文学を教えるようになった。

3) 文法、スペリングが中心とされた時代 1946—1972(キリル文字の導入)

1946年から公務事業にキリル文字が使用されるようになった。これにしたがって、初・中等学校の授業もキリル文字によって行われるようになった。そのため、学習カリキュラムの概念には音声、語彙、文章構成、文体のほか新文字によるスペリング基準の授業の示す割合がかなり増加したのである。

4) 対話・表現能力の向上に力を入れた時代

総合教育学校の4学年目に音声、スペリング基準、5学年目に語彙、7学年目に文の構成、8学年目に語彙、9—10学年目に文体といった言語学の概念がそれぞれ教えられていた。この時のカリキュラムの内容を見ると書き記すつまり文章表現科目はわずか4パーセントを示していた。義務教育学校を卒業するのに簡単な表現もできずにいる、この現状に対して、教官や関係者が不満をいただいていた。そのため、1972年に学習カリキュラムを改革する際に、学年ごとに会話・表現の実践授業時間が施され、1985年にこの授業の内容が明らかにされた。

1960年代の半ばごろから7、8学年、1976年から4—6学年において文学の科目が導入されるようになった。2000年までは文学学習カリキュラムの概念には必読文学作品のリストが作られた。その内容は、モンゴル口承文学、モンゴル古典文学、モンゴル現代文学、海外文学によって構成されていた。この時代には、文学科目によって学習される文学作品選択が一党のイデオロギーに直接影響されていたが、当時の授業内容は比較的安定していたところもある。

1987年から総合教育学校の7, 8学年において、モンゴルたて文字を教えるようになった。1991—1994年に総合教育学校の初等教育科目の学習は全部モンゴルたて文字によって教えられ、5学年目から、つまり1995年から3—8学年までモンゴルたて文字が教えられていた。

5) テキストを根拠にする文法、表現力に重点を置いた時代 1998、2004—2013—2016

1998年に総合教育学校の学習カリキュラムの内容の基準、2004年に総合能力に基づく基準、2012年に12学年制度学習プログラムがそれぞれ確定された。これらの基準・プログラムの作成にはテキストを根拠にする生きた文法に重点を置いたのである。現状から引き離れた、使用されない内容の教訓が拒否されるようになったのである。2009年に、初等学年、2014年から中・高等学年に学習する「核」プログラム(Цөм хөтөлбөр)の構成を読む、書く、話す、聴くに分けたのである。

3. 読む能力

初等学年: 子供たちが一学年に入学したときから、彼らの読む能力の向上に心がけている。1998年までは、初等学年ではモンゴル国語の授業は一週間に11—14時間分配され、その中で6時間程度が読書の授業だった。最近、モンゴル語学の授業に分配される時間が減少されてきている。それに伴い、読書授業の時間も減っている。初等学年に分配される読書時間以外に、放課後に読書活動が行われている。

初等学年向けに「読書」という教科書を作り、学習に使用してきた。2000年からこのような教科書づくりが停止され、「モンゴル語」という教科書が作成され始めた。その教科書の実践活動にはテキストやそれに関連する問題などがある。

初等学年における読書授業の目的:

- テキストを正しく、よく理解し、速く、きれいに読むといった四つの力を使えるようにする。
- 本を正しく扱う方法を教え、自ら読書を好むようにする
- 読解・表現科目学習によって、環境・社会生活におけるダイナミックな現象、その構成に関する知識を得る
- 表現力を伸ばす
- 道徳・美学の知識を与える

中・高等学年: 総合教育学校の中・高等学年において、文学の科目には独自の時間が施され、教科書もある。目的は、生徒たちの読書する興味を引き出し、その文章を通して彼らが道徳的に育成されていけるようにすることである。一週間に2時間勉強する。比較的安定している。

1960年から、文学の授業が4—8学年に読解として学習され、高等学年では社会面から勉強されてきた。例えば、4—8学年の文学本の読解の目的というと:

- 読書に関心を持つようにする、本が好きになる、テキストを根拠にして解釈ができるようになる
- あやまりなく、よく理解して読めるようにすることである。

9, 10学年の文学科目の目的は;

- 歴史的な根拠に基づいた、当時の先進的な思想によって書かれた文学作品は社会生活に道徳的に影響を与える。学習者に、そのような相互作用の体制を理解してもらう。

1990年代以後、モンゴル国は民主主義社会に移行した。それに伴い、読書・文学の学習カリキュラムの内容が改革されるようになった。

- イデオロギー的な思想を強く受けた古い内容が取り除かれ、モンゴルの習慣、仏教、道徳をテーマにした文学作品が導入されるようになった。
- 古典文学・口承文学の作品が多く取り入れられた。
- 海外文学で内容が複雑な小説を取り除いた。
- 母国における現代的なイデオロギーのものを取り除き、最近の良く知られている作者による文学作品を取り入れた。

2004年の基準、12学年制度学校の全国学習プログラムには、文学科目学習概念が変更された形で取り入れられた。その変更内容は、文学科目によって学習される文学作品を内容を中心にして勉強するのではなく、その作品を根拠にしてなにかをできるようにすることである。つまり、以前のプログラムでは、学習すべき作品や作者に関する知識が重要視されていた。が、新プログラムでは、学習者が能率的に読解する能力を得ること、例えば、読み終わった文章について考慮する、反省する、解釈する、分析するといった想像的で創造的な能力を得ることが重視されている。

最近、中・高等学年で学習する文学科目概念の中に次のような変更が導入されている。例えば、中等学年でのプログラム(2015年)では、

- 言葉による芸術を理解し、それを受け止める力を得る
- 分析、解釈、比較、対比、連結、根拠づけるといった情報作成能力を得る
- 評論、説明文と文学文を作成する
- 個人と社会交流ができるようになる

高等学年でのプログラム(2016年)では、

- 文学作品の心理を理解する
- 作品に反映されている背景、つまり歴史、社会、文化といったテーマの範囲で考慮し、メタ的知識を解釈する
- 連続的な期間に、異文化の国々の、同一の話題・テーマを持つ作品の構成、テーマ、登場人物、環境、色彩といった成分を分析し、対比する
- 文学作品の種類、分類、表現の仕方、文体をリサーチする
- 感想、感覚などを表現し、対話する
- 作品に取り上げられた課題の中で意見を述べ、批判し、研究テキストを作成する
- 文学文を作成する

このように、読解・文学科目の学習内容を何回にもわたり変更・改善してきたが、現状が改善されていないのが以下の調査を見れば分かるかと思う。

2004、2008、2012年に、それぞれ学習者を対象に読解能力レベルを把握するのに行われた調査の結果はどれも悪かった。例えば、

- 2004～2006年に教育文化科学スポーツ省によって行われた「初等教育における学習成績の評価」全国調査では読解能力成績数値48,6%
- 2007～2008年に、文部文化科学省及び学習評価センターによって行われた「初等教育において、数学・読解能力を把握する全国調査」によると、読解能力の平均的数値は48%、テキストを根拠とする理解・解釈問題の数値は18%で、大変悪かった。
- 2012年に教育評価センターがした義務教育の実行水準を決定する試験では7学年の学習者の50,2%、10学年の学習者の47,9%が「F」評価を得た。

2007～2008年に、文部文化科学省及び学習評価センターによって行われた「初等教育において、数学・読解能力を把握する全国調査」の報告によると、読解能力の結果は二つある。

1. 国際基準の問題をいれて、成績をみると、平均数値は41,2%
2. 国際基準問題を取り除いて、成績を見ると、平均数値は48%で、国際基準問題の成績の平均数値は31,6%であった。

読解能力を調べる35問の問題の26問が選択問題、9問が解答問題であった。選択問題の数値は46,7%、解答問題の数値は36,6%だった。

最近の3年間に、文部文化科学省及び学習評価センターが共同で行なっている調査に使用された12学年の試験問題の内容が語学・文学科目の学習内容にあまり一致していなかった、また読解能力を十分に発揮で

きるような問題ではなかったことが学習者にとって困難であった理由である。2016年の学年度の受験問題を例として取り上げよう。

まとめ:

- 1) 総合教育学校において、モンゴル語学・文学科目の学習プログラムの改善は国際的に取り入れられている国語教育基準に合わせることを目標に、モンゴル語・文学学習の従来の伝統・経験・教訓に基づいて行われている。
- 2) 国語・文学科目に使用される文学・非文学作品の選択にかなり注意を払っている。生徒が学習する文章は彼らの育成に穏やかに影響するような、例えば、モンゴル語・文化、習慣・環境・教育などが手助けとなり、表現力が優れるものであることが重視されている。
- 3) 初・中・高等学校において取得される読解能力検定試験のテスト作成、国際的な基準にあった教授法などをさらに理解し、勉強する必要がある。

Уран зохиолын бус эхэд суурилсан даалгавар:

1. “Асралт хайрхны оргилд” эхийг 15 минутад унших

Гүйцэтгэх даалгавар: **75 минутад**

А. Уулын авиралтад оролцсон нэг залуу бэрхшээлийг бэлтгэлээр давдгийг ямар үг хэллэг, бичлэгийн ямар арга барил ашиглан өгүүлсэн байна вэ? Эхийн үг хэллэг, бичлэгийн арга барилыг өөрийн үгээр дүгнэн бичээрэй.

Үгийн тоо 300-350 /25 оноо/

Б.“Асралт хайрхны оргилд” эхийн үг хэллэг, бичлэгийн ямар арга барил ашиглан үе тэнгийхнэдээ зориулан байгалийн сайхныг бахдан шагшсан, түүнийг хэрхэн хайрлан хамгаалах тухай тэмдэглэл, зөвлөгөө бичээрэй.

Үгийн тоо 300-350 /25 оноо/

Уран зохиолын бус эхэд суурилсан даалгавар:

2. “Зээ хүү” эхийг эхний 5 минутад унших

Гүйцэтгэх даалгавар: **40 минутад**

А. Ж.Сарантуяагийн “Зээ хүү” эхэд “Хар Жанлав зээгээ хэрхэн хайрлан, өмгөөлөн өсгөж байгаа тухай” тухай санааг дүрслэн өгүүлэхдээ ямар үг хэллэг, бичлэгийн арга барилыг ашиглан гаргасныг хамгийн багадаа 4 эшлэл баримт ашиглан тайлбарлаарай.

Үгийн тоо 300-350 /25 оноо/

Б.Дараах сэдвээс зөвхөн НЭГИЙГ сонгон эх зохион найруулж бичнэ.

Үгийн тоо 300-350 /25 оноо/

- “Алаг дэлхийд төрсөн минь учиртай” санааг баримт мэдээгээр баяжуулан эх зохион найруулаарай.
- “Цөлийн диваажин болгосон нь” санааг уран сэтгэмжээр баяжуулан зөгнөн бичээрэй.
- “Залуу хүний заавал унших ном” сэдвээр найз нөхдөө унштал ухуулж ятгасан эх зохион найруулж бичээрэй.

Үгийн тоо 300-350 /25 оноо/

“ЭХ ХЭЛНИЙ СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР БА УНШИХ ЧАДВАР”

Ш.Оюунцэцэг (БМДИ-ийн ХНХНСА-ны дарга)

Нэг. Боловсролын салбарын хөгжил

1921 онд Монгол улсад орчин цагийн боловсрол үүссэн гэж үздэг бөгөөд тус улсад орчин цагийн гэгээрэл, боловсролын талаар дараах зорилт дэвшүүлж, хэрэгжүүлжээ¹. Үүнд:

1. 1921-1940 Сургууль, гэгээрлийн байгууллага байгуулагдаж, бичиг үсэгт тайлах зорилтыг хэрэгжүүлсэн үе (17%)
2. 1941-1958 Бүх нийтийг бага боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн үе
3. 1958-1986 Сургуулийн насны бүх хүүхдийг дунд боловсролтой болгох зорилтыг хэрэгжүүлсэн үе
4. 1990-оноос Боловсролын тогтолцоог шинэчлэх, олон улсын жишигт нийцүүлэх зорилтыг хэрэгжүүлж байгаа үе

Ерөнхий боловсролын сургуулийн бүтэц өөрчлөгдөж ирсэн. Тухайлбал, 1950-аад онд 7 жил, 1960-аад оноос 8, 10 жилийн сургалттай сургуулиуд байгуулагдаж эхэлсэн. Ерөнхий боловсролын 10 жилийн сургуулиуд 2005 оноос 11, 2013 оноос 12 жилийн сургалттай болсон. Хүүхдийн сургуульд элсэх насыг 2004 оноос 7, 2008 оноос 6 нас болгож урагшлуулсан.

Хоёр. Монгол хэл бичгийн сургалтын агуулгын хөгжил

Монголчуудын уламжлалт гэрийн сургалт болон төрийн сургуульд үздэг үндсэн хичээл бол монгол хэл бичгийн хичээл юм. Монгол хэл бичгийн уламжлалт сургалтын агуулга нь монгол үсгийн цагаан толгой зааж, уншуулж бичүүлж сургах агуулга байв.

Энэ баялаг уламжлал дээр тулгуурлан орчин цагийн монгол хэл бичгийн сургалтын агуулга хөгжиж ирсэн. 1921-1941 онд ерөнхий боловсролын сургуулийн сургалтыг үндэсний монгол бичгээр, 1941 оноос шинэ монгол бичиг буюу кирилл үсгээр явуулж байна.

Монгол хэл бичгийн сургалтын агуулгын хөгжлийг дараах үе шатад хувааж болно². Үүнд:

1. Уламжлалт сургалтын агуулга зонхилсон үе 1921-1934 (үндэсний бичиг)

Энэ үеийн сургалтын гол агуулга нь унших, бичих, зохиох. Сурагчдыг монгол үсгийн цагаан толгойд сургаж, аль болох их уншуулж, сайхан бичүүлэх, тэдний ярих, бичих чадварыг хөгжүүлэхэд чиглэсэн дадлага ажил голлож байв.

2. Хэл зүй зааж эхэлсэн үе 1934-1946 (үндэсний бичиг)

Бага сургуулийн монгол хэл бичгийн уламжлалт агуулга өргөжиж, 1934 оноос хэлний зүйн агуулга шинээр нэмэгдсэн. 1941 оноос бага, дунд сургуульд шинэ үсэг буюу кирилл бичиг зааж эхэлсэн. Монгол хэл бичгийн сургалтын хөтөлбөрт авиа зүй, үг зүй, өгүүлбэр зүйн агуулга жилээс жилд нэмэгдэж, бараг 70 орчим хувийг эзлэх болсон. 1940 оноос дунд сургуулийн 9-10 дугаар ангид гадаадын уран зохиол заах болсон.

3. Хэл зүй, зөв бичих дүрмийг дагнан заасан үе 1946-1972 (шинэ үсэг буюу кирилл бичиг)

1946 оноос эхлэн төрийн албан хэргийг шинэ кирилл үсгээр хөтөлж эхэлсэнтэй холбогдуулан бага, дунд сургуулийн сургалт шинэ кирилл бичигт шилжсэн. Ийм учраас сургалтын хөтөлбөрт авиа зүй, үг зүй, үг зүй, өгүүлбэр зүй, найруулга зүйгээс гадна шинэ үсгийн зөв бичих дүрмийн агуулга нэлээдгүй хувийг эзлэх болсон.

4. Яриа бичгийн чадварт анхаарч эхэлсэн үе 1972-1998

Дунд сургуулийн 4-р ангид авиа зүй, зөв бичих дүрэм, 5-р ангид үг зүй, 7-р ангид өгүүлбэр зүй, 8-р ангид үгийн сан, 9-10-р ангид найруулга зүй гэх мэтээр хэлний салбар ухааныг анги ангид төрөлжүүлэн зааж байсан. Энэ үед бичиж найруулах дадлага ажил хөтөлбөрийн 4 хувийг л эзэлж байв. Дунд сургууль төгсөгчид наад захын зүйлийг бичиж найруулж чадахгүй байгаад багш, судлаачид шүүмжлэлтэй хандаж байв. Ийм учраас 1972 онд сургалтын хөтөлбөрийг шинэчлэхдээ

¹Ш.Шагдар, “Монгол улсын боловсролын түүхэн товчоон”, Уб, 2000 он, 323-326-р тал

²Ш.Оюунцэцэг, Монгол хэл бичгийн сургалтын агуулгын хөгжил”, “ ”, Уб, 2000, ...-р тал

анги бүрд яриа бичгийн дадлага хичээлийн цаг хуваарилж, 1985 онд энэ цагт заах агуулгыг тогтоож өгсөн.

1960-аад оны дунд үеэс 7-8-р анги, 1976 оноос 4-6 дугаар ангид уран зохиолын хичээл заах болсон. 2000-аад он хүртэл уран зохиолын сургалтын хөтөлбөрийн агуулга заавал унших зохиолуудаас бүрдэж байсан. Уран зохиолын хичээлээр уншиж судлах зохиол нь 1. монгол аман зохиол, 2. Монголын эртний сонгодог уран зохиол, 3. Монголын орчин үеийн уран зохиол, 4. гадаадын уран зохиолоос бүрдэж байсан. Энэ үеийн уран зохиолын хичээлээр судлах зохиолын сонголт нэг намын үзэл суртлаас шууд хамааралтай байсан учир тухайн үеийн агуулга харьцангуй тогтвортой байсан.

1987 оноос ЕБС-ийн 7,8 дугаар ангид монгол бичгийн хичээл зааж эхэлсэн. 1991-1994 онд ЕБС-ийн бага ангийн сургалтыг бүхэлд нь монгол бичгээр сургалт явуулж, 5-р ангиас эхлэн, 1995 оноос 3-8-р ангид монгол бичгийн хичээл заасан.

5. Эхэд суурилсан хэл зүй буюу хэлний хэрэглээний чадварт анхаарсан үе 1998, 2004-2013-2016

1998 онд ЕБС-ийн сургалтын агуулгын стандарт, 2004 онд баталсан цогц чадамжид суурилсан стандарт, 2012 онд 12 жилийн сургуулийн сургалтын хөтөлбөр тус тус батлагдсан. Эдгээр стандарт, хөтөлбөрийг боловсруулахдаа эхэд суурилсан хэрэглээний хэл зүйг чухалчилж, амьдралаас тасархай “нүцгэн” хэл зүй заахаас татгалзсан. 2009 онд бага анги, 2014 оноос дунд, ахлах ангийн цөм хөтөлбөрийн агуулгыг унших, бичих, ярих-сонсох гэсэн бүрэлдэхүүн хэсэгтэй болгосон.

Гурав. Унших чадвар

Бага анги. Сурагчдыг нэгдүгээр ангид элссэн үеэс эхлэн унших чадварыг хөгжүүлж байна. 1998 он хүртэл бага ангийн монгол хэлний хичээл долоо хоногт 11-14 цаг оногдож, үүнээс 6 орчим цагт сурагчдын унших чадварыг хөгжүүлэх хичээл зааж ирсэн. Сүүлийн жилүүдэд монгол хэлний хичээлд оногдох цаг багасч байгаатай холбоотойгоор уншихын хичээлийн цаг ч бага болж байна. Бага ангид уншихын хичээлээс гадна хичээлээс гадуурх уншлагаар зохион байгуулж ирсэн. Бага ангид “Унших бичиг” гэсэн тусгай сурах бичиг хэвлэж, сургалтад ашиглаж ирсэн. 2000 оноосийнхүү тусгай сурах бичиг хэвлэхээ больж, “Монгол хэл” гэсэн нэг сурах бичигтэй болж, уншлагад зориулсан сэдэв, даалгаврыг багтаах болсон.

Бага ангийн уншлагын хичээлийн гол зорилго нь:³

- ✓ Сурагчдад уншлагын зөв, ойлгож, хурдан, уран яруу унших дөрвөн чанарыг эзэмшүүлэх
- ✓ Сурагчдыг номыг зөв ашиглах дадал чадвартай, ном унших дур сонирхолтой болгох
- ✓ Унших-үг хөгжлийн хичээл нь хүрээлэн байгаа орчин, байгаль нийгмийн амьдралын олон талт үзэгдэл, хууль зүй тогтлын талаар мэдлэг эзэмшүүлэх
- ✓ Уншлагын дадал чадвар олгох явцад сурагчдын хэл яриаг хөгжүүлэх
- ✓ Унших-үг хөгжлийн хичээлээр дамжуулан сурагчдын ёс суртахуун, гоо зүй, хөтөлбөрийн хүмүүжилд нөлөөлөх

Дунд, ахлах анги. Ерөнхий боловсролын суруулийн дунд, ахлах ангид уран зохиолын хичээл тусдаа цагтай, тусдаа сурах бичигтэй хичээллэж байна. Уран зохиолын хичээл нь сурагчдын унших сонирхлыг өрнүүлж, уран зохиолоор дамжуулан сурагчдын хүмүүжил төлөвшилд эерэг нөлөө үзүүлэх, ёс суртахууны боловсролыг дэмжих зорилготой. Уран зохиолын хичээлд долоо хоногт 2 цаг оногдож байгаа байгаа бөгөөд энэ цаг харьцангуй тогтвортой байсаар ирсэн.

1960-аад оноос уран зохиолын хичээлийг 4-8-р ангид уншлагын, ахлах ангид уран зохиолын хичээлийн нийгэмд гүйцэтгэх үүргийн талаас нь судлах мэдлэг чадвар эзэмшүүлэхэд чиглэж байсан. Тухайлбал,

*ГҮ-ҮШ ангид уран зохиолын уншлагын зорилго:*⁴

³“Ерөнхий боловсрол, политехникийн дунд сургуулийн I-III сургуулийн ангийн хичээл, багш нарын мэргэжил дээшлүүлэх программ”, Уб, 1981 он, 6-7-р тал

⁴Программ (Монгол хэл, уран зохиол), Уб, 1985, 66-67-р тал

- Сурагчдын ном унших сонирхлыг өрнүүлэх, номд дуртай болгох, эх зохиолд үндэслэлтэй тайлбар хийж сургах
- Алдаагүй зөв, шударга, уран яруу, утга төгөлдөр, ойлгож унших чадварыг сурагчдад эзэмшүүлэх зорилготой.

IX-X ангийн уран зохиолын хөтөлбөрийн зорилго:

- Агуулга нь түүхэн зарчмыг үндэс болгож, тухайн цаг үеийн тэргүүний үзэл санаа, нийгмийн амьдралд уран зохиолын гүйцэтгэх үүрэг, тэдгээрийн холбоог сурагчдад системтэй ойлгуулах зорилготой.

1990-ээд оноос Монгол орон ардчилсан нийгэмд шилжсэнээр унших, уран зохиолын сургалтын агуулгад дараах өөрчлөлт орсон⁵. Үүнд:

- Үзэл суртлын хүчтэй нөлөөн дор хийгдсэн хуучин агуулгаас татгалзаж, монгол заншил, бурхны шашин, ёс суртахууны сэдэвт зохиолыг нэмсэн.
- Үндэсний уламжлалт бичгийн зохиол, ААЗ-ыг түлхүү оруулсан.
- Дэлхий сонгодог зохиолоос хүнд, ховор зохиолыг агуулгаас хассан.
- Монголын орчин үеийн зарим үзэл суртлын зохиолыг хасаж, сүүлийн үеийн нэрд гарсан зохиолчдын бүтээлээс оруулсан.

2004 оны стандарт, 12 жилийн сургуулийн үндэсний сургалтын хөтөлбөрт уран зохиолын сургалтын хөтөлбөрийн агуулгыг өөрчилж, уран зохиолын хичээлээр судлах зохиолуудыг агуулгын төвд тавихаас татгалзаж, харин тодорхой зохиолыг судлах явцад эзэмших чадварыг хөтөлбөрийн агуулга болгож оруулсан. Өөрөөр хэлбэл, өмнө нь хөтөлбөрт байгаа зохиол, зохиолчийн тухай мэдлэгтэй байхыг чухалчилдаг байсныг өөрчилж, сурагчдад бүтээлчээр унших арга барил эзэмшүүлэх, тухайлбал, уншсан зохиолыг эргэцүүлэх, тусган хүлээж авах, өөрийнхөөрөө тайлан тайлбарлах, зохиолын утга агуулга болоод хэл найруулгад дүн шинжилгээ хийх зэрэг бүтээлч чадвар эзэмшүүлэхэд анхаарч байна.

Сүүлийн жилүүдэд дунд, ахлах ангийн уран зохиолын сургалтын хөтөлбөрт дараах өөрчлөлт орж байна. Тухайлбал, дунд ангийн хөтөлбөр (2015 он)-т:

- ✓ Үгийн урлагийг мэдэрч, тусган хүлээж авах чадвар
- ✓ Задлан шинжлэх, тайлан тайлбарлах, харьцуулах, эсрэгцүүлэх, холбоослох, үндэслэх зэрэг мэдээлэл боловсруулах чадвар
- ✓ Шүүмжлэх ба бүтээх чадвар: аналитик бичвэр ба уран дүрслэлт бичвэр бүтээх
- ✓ Хувийн болон нийгмийн харилцааны чадвар

Ахлах ангийн хөтөлбөр (2016 он)-т:

- ✓ Яруу найраг, үргэлжилсэн үг, жүжгийн хэлбэрээр бичсэн сэтгэл зүйн зохиолыг мэдэрч хүлээн авах
- ✓ Зохиолд туссан түүх, нийгэм, соёлын хам сэдвийн хүрээнд эргэцүүлэх, далд санааг ойлгох
- ✓ Өөр өөр цаг үеийн, өөр өөр соёлын ижил сэдэвтэй зохиолын бүтэц, утга сэдэв, дүр, орчин, өнгө аяс зэрэг бүрэлдэхүүн хэсгийг задлан шинжилж, харьцуулах
- ✓ Уран зохиолын төрөл зүйл, ангилал, бичлэгийн хэлбэр, хэл найруулгыг судлах
- ✓ Уншсан зохиолоос төрсөн сэтгэгдэл, мэдрэмжээ илэрхийлэн харилцах
- ✓ Зохиолд дэвшүүлсэн асуудлын хүрээнд үзэл бодлоо илэрхийлэх, шүүмжлэлтэй хандаж, судалгааны бичвэр бүтээж эхлэх
- ✓ Зохиолын хэлбэр, бүтэц, хэл найруулгаас суралцан уран дүрслэлт бичвэр бүтээх

Ийнхүү унших, уран зохиолын сургалтын агуулгыг хэд хэдэн удаа шинэчилсэн боловч үр дүн төдийлөн сайн биш байгаа нь дараах судалгаанаас харагдаж байна. 2004, 2008, 2012 онд сурагчдын унших чадварын түвшнийг судалсан судалгаанаас хийсэн үр дүнгээс үзэхэд маш тааруухан үзүүлэлтэй байсан. Тухайлбал,

⁵Монголын бага, дунд боловсролын агуулга, арга зүйн хөгжлийн товч тойм (1911-2000), Уб, 2001 он, 76-77-р тал

- 2004-2006 онд БСШУЯ-аас хийсэн “Бага боловсролын сурлагын амжилтын үнэлгээ” үндэсний судалгаагаар унших чадварын онооны гүйцэтгэл 48,6%⁶
- 2007-2008 онд БСШУЯ, БҮТ-ээс зохион байгуулсан “Бага боловсролын математик, унших чадварын үндэсний хэмжээний судалгаа”-аар унших чадварын дундаж 48%, эхийн утгыг ойлгох, эхийн утга санааг олох даалгаврыг 18,0 хувьтай буюу маш хангалтгүй гүйцэтгэсэн⁷
- 2012 онд БҮТ-өөс стандартын хэрэгжилтийн түвшин тогтоох шалгалтаар 7-р ангийн сурагчдын 50,2%, 10-р ангийн сурагчдын 47,9% нь “F” түвшинд үнэлэгдсэн.⁸

2007-2008 онд БСШУЯ, БҮТ-ээс зохион байгуулсан “Бага боловсролын математик, унших чадварын үндэсний хэмжээний судалгаа”-ны тайлангаас үзэхэд унших чадварын дүнг хоёр байдлаар гаргажээ.

1. Олон улсын даалгаврыг оруулан дүнг шинжлэхэд гүйцэтгэлийн дундаж онооны хувь 41,2%
2. Олон улсын даалгаврыг оруулахгүйгээр дүнг шинжлэхэд гүйцэтгэлийн дундаж онооны хувь 48%, олон улсын даалгаврын гүйцэтгэлийн дундаж онооны хувь 31,6% байв.
3. Сүүлийн 3 жилд БСШУЯ, БҮТ-өөс зохион байгуулж байгаа чанарын үнэлгээний судалгаанд ашигласан 12 дугаар ангийн шалгалтын сэдэв монгол хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөрт сайн нийцээгүйн зэрэгцээ унших чадварыг бүрэн илрүүлж чадахгүй даалгавар байсан сурагчдад ихээхэн бэрхшээлтэй байжээ. 2016 оны шалгалтын сэдвийг жишээлэн үзүүлбэл:

Унших чадварын 35 даалгаврын 26 нь сонгох, 9 нь завдгай хариулттай даалгавар байсан бөгөөд сонгох хариулттай даалгаврын гүйцэтгэл 46.7%, задгай хариулттай даалгаврын гүйцэтгэл 36.6% байжээ.

ДҮГНЭЛТ:

1. ЕБС-ийн монгол хэл, уран зохиолын сургалтын хөтөлбөрийг монгол хэл, уран зохиолын сургалтын өнөө хүрсэн уламжлал, туршлага, сургамжид үндэслэн, олон улсад эх хэлний боловсрол олгож байгаа жишигт нийцүүлэхийг зорьсон шинэчлэл хийж байна.
2. Монгол хэл, уран зохиолын сургалтад ашиглах зохиол бүтээлийг сонголтод ихээхэн анхаарч байна. Сурагчдаар судлуулах зохиол бүтээл нь сурагчдын хүмүүжил төлөвшилд эерэг нөлөө үзүүлэхээр, тухайлбал, монгол хэл соёл, уламжлалт ахуй, зан заншил, байгаль орчин, тогтвортой хөгжлийн боловсролд хувь нэмэр оруулах агуулгатай, хэл найруулгын хувьд үлгэр жишээ болохуйц байхыг чухалчилж байна.
3. Бага, дунд, ахлах ангид сурагчдын эзэмшсэн унших чадварын түвшин тогтоох даалгавар боловсруулах, ялангуяа олон улсын жишигт нийцсэн арга зүйд суралцах шаардлагатай байна.

⁶<http://www.eec.mn/page/77/0>

⁷“Бага боловсролын математик, унших чадварын үндэсний үнэлгээ”, БҮТ, 2008,38-р тал)

⁸http://www.eec.mn/page/судалгааны_дүн_162/0